

ЗАХ ЗЭЭЛИЙН ТОЙМ

06.22 - 06.26



ОЛОН УЛСЫН ЗАХ ЗЭЭЛИЙН МЭДЭЭ

АНУ: Эдийн засгийн зарим үзүүлэлтүүд эерэг гарсан ч шинэ төрлийн коронавирусийн дахин тархалтын болгоомжлолоос үүдэн АНУ-ын хөрөнгийн зах зээлийн индексүүд энэ долоо хоногт уналттай хадгаллаа. Технологийн компаниудыг илүүтэйгээр агуулдаг Nasdaq Composite индекс бусад индексүүдтэйгээ харьцуулахад хамгийн ихээр өсөлттэй байлаа. S&P 500 индекс уналтад орж "correction" бүсэд буюу 02-р сарын дээд түвшнээсээ 10%-аас илүү буурсан байна.

Энэ долоо хоногт хөрөнгийн зах зээл бүхэлдээ савлагаатай байсан ч банкны салбарт үйл ажиллагаа явуулдаг компанийн хувьцаанууд хамгийн их савлагаатай байлаа. Пүрэв гарагт Холбооны Нөөцийн Сангаас 2008-2009 оны эдийн засгийн хямралын үед авч хэрэгжүүлсэн байсан арга хэмжээг цуцлан, зарим нэг нөөцийн шаардлагуудыг бууруулж, тодорхой төрлийн эрсдэлтэй хөрөнгө оруулалтыг хийхийг зөвшөөрөхөө мэдэгдсэнтэй холбоотой санхүүгийн салбар өсөлттэй байсан ч Баасан гарагт Холбооны Нөөцийн Сан, банкнуудын ногдол ашиг тараах болон хувьцаа халааслах үйл явцад хязгаарлалт тавихаар төлөвлөж байгаа мэдээлэл гарсантай холбоотой санхүүгийн салбар уналтад орсон байна.

Европ: АНУ болон Европ хоорондын худалдааны маргаан болон шинэ төрлийн коронавирусийн дахин дэгдэх эрсдэлээс үүдэн Европын хөрөнгийн зах зээлийн индексүүд уналттай байлаа. Европын хөрөнгийн зах зээлийн бүхэлд нь харуулдаг STOXX Europe 600 индекс долоо хоногийн төгсгөлд 1.89%-аар буурсан бол DAX индекс 2.09%, FTSE MIB индекс 2.33%, CAC-40 индекс 1.34%, FTSE 100 индекс 0.87%-аар тус тус буурсан байна.

Коронавирус цар тахалтай холбоотойгоор уналтад ороод байсан Евро бүсийн эдийн засгийн үзүүлэлтүүд хүлээлтээс өндөр гарснаар бүс нутгийн эдийн засаг огцом өсөлт үзүүлж магадгүй гэсэн найдварыг төрүүлж байна.

Япон: Энэ долоо хоногт Япон улсын хөрөнгийн зах зээлийн индексүүд харьцангуй өсөлт багатай байлаа. Nikkei 225 индекс 33.29 функт буюу 0.15%-аар өсөж 22,512.08 нэгж хүрсэн бол Япон улсын хөрөнгийн зах зээлийн ерөнхий хэмжүүр болох TOPIX индексүүд бага хэмжээний өөрчлөлттэй байв. 05 болон 06-р сарын хүчтэй сэргэлтийн дараагаар Япон улсын хөрөнгийн зах зээлийн индексүүд 2 долоо хоног дараалан зогсонги байдалд ороод байна.

Зарим улсуудад коронавирусийн шинэ тохиолдлын тоо нэмэгдэж байгаа болон худалдааны маргаантай холбоотой Япон улсын хөрөнгийн зах зээлийн индексүүд бууралттай байсан ч Пүрэв гарагт АНУ-ын хөрөнгийн зах зээлийн өсөлтийн нөлөөгөөр Баасан гарагт Япон улсын индексүүд эргэн сэргэсэн байна.

БНХАУ: БНХАУ-ын эдийн засгийн томоохон үзүүлэлтүүд эерэг байсантай холбоотой БНХАУ-ын хөрөнгийн зах зээлийн индексүүд өсөлттэй байлаа. CSI 300 индекс 1.0-аар өссөн бол Shanghai Composite индекс 0.4%-аар өссөн байна. Пүрэв гарагт БНХАУ-ын эрх баригчид 07-р сарын 23-наас эхлэн "сөрөг жагсаалт"-ын хэмжээг бууруулах замаар гадаадын шууд хөрөнгө оруулалт авах боломжтой салбарын тоог нэмэгдүүлнэ гэж мэдэгдсэн ба энэ нь коронавирусийн тархалтаас үүдсэн эдийн засгийн хүнд байдлын эсрэг авч буй арга хэмжээ гэж шинжээчид үзэж байна.

Эх сурвалж: Troweprice.com

Олон улсын индексүүд	Улс	Хаалт	Өөрчлөлт
MSE TOP 20	Монгол	16,160.76	-0.27% ▼
Dow Jones	АНУ	25,015.45	-3.31% ▼
S&P 500	АНУ	3,009.05	-2.86% ▼
Nasdaq	АНУ	9,757.22	-1.90% ▼
S&P/TSX	Канад	15,188.98	-1.84% ▼
FTSE 100	Их Британи	6,159.30	-2.12% ▼
S&P/ASX 200	Австрали	5,904.10	-0.65% ▼
Nikkei 225	Япон	22,512.08	0.15% ▲
Hang Seng	Хонг Конг	24,549.99	-0.38% ▼

Бонд	Валют	Купон	Үнэ
Mongol 2024 (Хуралдай)	USD	8.750%	108.13
Mongol 2023 (Гэрэгэ)	USD	5.625%	100.19
Mongol 2022 (Чингис)	USD	5.125%	99.67
Mongol 2021 (Мазаалай)	USD	10.875%	104.24
DBM' 23 (Самурай)	JPY	1.520%	100.68
DBM' 2023	USD	7.250%	97.52
MGMTGE' 2022 (Өүлэн)	USD	9.750%	87.94

Зах зээлийн хүү	Хаалт	Өөрчлөлт
Libor 1M	0.178	-0.06 ▼
Libor 3M	0.308	0.01 ▲
Libor 6M	0.361	-0.13 ▼
Libor 1YR	0.566	-0.02 ▼
US 2YR Bond	0.168	-0.10 ▼
US 3YR Bond	0.187	-0.15 ▼
US 5YR Bond	0.304	-0.07 ▼
US 10YR Bond	0.643	-0.07 ▼

Валютын ханш	2020.06.26	Өөрчлөлт
USD	2,821.08	0.05% ▲
CNY	398.56	0.06% ▲
EUR	3,167.79	0.23% ▲
RUB	40.78	0.59% ▲
KRW	2.35	0.86% ▲
JPY	26.38	0.08% ▲
CAD	2,065.97	-0.49% ▼

Түүхий эд	Хэмжих нэгж	Хаалт	Өөрчлөлт
Алт /спот/	USD/t oz.	1,771.29	1.57% ▲
Мөнгө /спот/	USD/t oz.	17.81	1.02% ▲
Зэс	USD/lb.	267.90	1.94% ▲
Нүүрс	USD/MT	54.53	0.76% ▲
WTI газрын тос	USD/bbl.	38.49	-3.17% ▼
Brent газрын тос	USD/bbl.	41.02	-2.77% ▼
Байгалийн хий	USD/MMBtu	1.50	-10.18% ▼

Макро эдийн засгийн үзүүлэлтүүд	Хугацаа	Хэмжээ
Инфляцийн түвшин	2020.V	3.30%
Бодлогын хүү	2020.V	9.00%
Банк хоорондын зах зээлийн хүү	2020.V	8.93%
Хадгаламжийн дундаж хүү /төгрөг/	2020.V	11.20%
Хадгаламжийн дундаж хүү /валют/	2020.V	4.48%
Зээлийн дундаж хүү /төгрөг/	2020.V	17.06%
Зээлийн дундаж хүү /валют/	2020.V	10.41%


Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо, Монголбанк, Bloomberg

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖИЙН АРИЛЖАА

Энэ 7 хоногт Монголын хөрөнгийн биржийн хоёрдогч зах зээлийн энгийн арилжаагаар нийт 36 компанийн 677.3 сая төгрөгийн 1,211,709 ширхэг хувьцаа арилжаалагдав. “Баянгол зочид буудал” /BNG/ компанийн хувьцаа 12.99%-аар буюу хамгийн ихээр өсөж 29,400.00 төгрөг хүрч хаагдсан бол “Э-Транс ложистикс” /ETR/ компанийн хувьцаа 17.72%-аар буурч 130.00 төгрөгт хүрч хаагдлаа.

Мөн тайлант долоо хоногт ЗГҮЦ-ны анхдагч болон хоёрдогч зах зээл дээр арилжаа хийгдээгүй.

06-р сарын 26 -ны өдрийн байдлаар зах зээлийн үнэлгээ 2,463.9 тэрбум төгрөгт хүрсэн бол MSE TOP-20 Индекс 16,160.76 нэгж болж, өмнөх 7 хоногийн үзүүлэлтээс 0.27% -аар буурсан байна.



Зах зээлийн тойм	Дүн (сая.төг)	
Арилжигдсан үнийн дүн	677.3	
Зах зээлийн үнэлгээ	2,463,923.8	
Зах зээлийн индексүүд	Хаалт	Өөрчлөлт
MSE Top 20	16,160.76	-0.27% ▼
MSE I индекс	7,989.01	0.55% ▲
MSE II индекс	7,283.75	-1.32% ▼
Идэвхтэй арилжагдсан хувьцаа	Ширхэг	Үнийн дүн
Махимпекс	227,551	550,679,295
Инвекор ББСБ	15,148	37,585,747
АПУ	47,219	25,575,998
Лэндмн ББСБ	683,885	20,949,464
Таван толгой	1,803	9,901,165
Өсөлттэй хувьцаа	Хаалт	Өөрчлөлт
Баянгол зочид буудал	29,400.00	12.99% ▲
Улсын их дэлгүүр	896.62	12.08% ▲
Шарын гол	1,236.00	8.52% ▲
Багануур	949.50	5.50% ▲
Талх чихэр	11,500.00	4.55% ▲
Бууралттай хувьцаа	Хаалт	Өөрчлөлт
Э-Транс ложистик	130.00	-17.72% ▼
Монгол базальт	194.90	-9.32% ▼
Ард санхүүгийн нэгдэл	1,250.00	-5.23% ▼
Ард кредит ББСБ	68.03	-4.02% ▼
Дөрвөн - Уул	560.00	-3.45% ▼
Арилжаанд идэвхтэй оролцсон ҮЦК	Дүн (төг)	
БиДиСек	1,144,255,482	
Ти Ди Би Капитал	38,689,966	
Инвекор Капитал	30,091,747	
Бумбат-Алтай	21,110,665	
Мирэ Эссет Секьюритис Монгол	17,824,601	
Зах зээлийн үнэлгээ хамгийн өндөр 5 компани	Хаалт (төг)	33Ү (сая.төг)
АПУ	542.00	576,691
Таван толгой	5,500.00	289,659
МИК холдинг	12,990.00	269,014
Инвекор ББСБ	2,515.00	180,396
Говь	193.00	150,655

Засгийн газрын үнэт цаасны хоёрдогч зах зээлийн арилжаа

№	Үнэт цаасны нэр	Арилжигдсан ширхэг	Үнийн дүн /төг/	Доод /төг/	Дээд /төг/	7 хоног	Хүү
-	-	-	-	-	-	-	-

НОГДОЛ АШИГ ЗАРЛАСАН ХУВЬЦААТ КОМПАНИУД

№	СИМБОЛ	КОМПАНИЙН НЭР	2019 ОНЫ ЦЭВЭР АШИГ /САЯ ТӨГ/	НИЙТ ХУВААРИЛАХ НОГДОЛ АШИГ /САЯ ТӨГ/	НОГДОЛ АШИГ ТӨЛӨЛТИЙН ХАРЬЦАА	НЭГЖ ХУВЬЦААНЫ НОГДОЛ АШИГ /ТӨГ/	БҮРТГЭЛИЙН ӨДӨР	ХУВААРИЛАХ ӨДӨР
1	APU	АПУ	74,411.5	75,471.2	101.4%	71.0	2020.02.14	2020.08.31-НИЙ ДОТОР
2	MNDL	МАНДАЛ ДААТГАЛ	5,820.3	2,497.2	42.9%	4.0	2020.04.01	2020.06.30-НЫ ДОТОР
3	GTL	ГУТАЛ	2,403.7	2,436.0	101.3%	1,520.0	2020.03.13	2020.05.05-НЫ ӨДӨР
4	LEND	ЛЭНДМН	4,910.2	1,200.0	24.4%	1.5	2020.02.25	2020.04.30-НЫ ӨДӨР
5	ADB	АРД КРЕДИТ ББСБ	2,369.4	1,184.7	50.0%	4.2	2020.04.08	2020.04.30-НЫ ДОТОР
6	AARD	АРД САНХҮҮГИЙН НЭГДЭЛ	715.9	1,000.0	139.7%	35.0	2020.04.07	2020.04.30-НЫ ДОТОР
7	TUM	ТҮМЭН ШУВУУТ	3,232.9	960.0	29.7%	4.8	2020.04.07	2020.06.24-НЫ ӨДӨР
8	AIC	АРД ДААТГАЛ	1,718.7	850.0	49.5%	34.0	2020.04.09	2020.06.30-НЫ ДОТОР
9	JTB	ЖЕНКО ТУР БЮРО	1,253.8	799.9	63.8%	10.0	2020.03.27	2020.06.30-НЫ ДОТОР
10	TEX	ТЕХНИК ИМПОРТ	2,718.2	723.4	26.6%	500.0	2020.03.01	2020.04.24-ӨӨС
11	BUK	УЛААНБААТАР БУК	2,465.3	526.2	21.3%	4.0	2020.03.30	2020.06.01-ЭЭС
12	MMX	МАХИМПЕКС	819.3	456.1	55.7%	120.0	2020.04.03	2020.10.01-ЭЭС
13	MFC	МОНОС ХҮНС	761.9	408.9	53.7%	1.0	2020.03.11	2020.08.31-НИЙ ДОТОР
14	DSS	ДАРХАН СЭЛЭНГИЙН ЦТС	581.8	391.8	67.3%	37.7	2020.03.20	2020.09.02-НЫ ӨДӨР
15	MNP	МОНГОЛ ШУУДАН	1,103.6	331.1	30.0%	3.3	2020.04.05	2020.05.01-ЭЭС
16	HRM	ГЕРМЕС ЦЕНТР	820.0	322.0	39.3%	4.1	2020.02.28	2020.03.15-ААС
17	NEH	ДАРХАН НЭХИЙ	2,327.6	230.8	9.9%	210.0	2020.02.25	2020.09.30-ААС
18	TCK	ТАЛХ ЧИХЭР	2,456.0	230.3	9.4%	225.0	2020.02.18	2020.06.20-ООС
19	MBW	МОНГОЛ БАЗАЛТ	335.0	225.7	67.4%	4.0	2020.03.09	2020.06.30-НЫ ДОТОР
20	BNG	БАЯНГОЛ ЗОЧИД БУУДАЛ	2,117.8	152.3	7.2%	360.0	2020.04.05	2020.09.01-НИЙ ӨДӨР
21	BDS	БИДИСЕК	19.9	136.9	687.0%	10.0	2020.03.09	2020.12.31-НИЙ ДОТОР
22	EER	АРИГ ГАЛ	225.8	131.0	58.0%	38.9	2020.03.27	2020.06.30-НЫ ДОТОР
23	ТАН	ТАХЬКО	489.0	128.5	26.3%	108.0	2020.04.10	2020.05.01-НИЙ ДОТОР
24	UBH	УЛААНБААТАР ХИВС	298.8	121.4	40.6%	300.0	2020.03.06	2020.05.01-ААС 2020.05.15-НЫ ХООРОНД
25	HRD	ХҮРД	722.6	72.4	10.0%	535.0	2020.03.02	2020.06.30-НЫ ДОТОР
26	ATR	АТАР ӨРГӨӨ	280.4	60.9	21.7%	350.0	2020.04.01	2020.08.01-НИЙ ДОТОР
27	MCH	МОНГОЛЫН ЦАХИЛГААН ХОЛБОО	62.0	25.9	41.7%	1.0	2020.04.06	2020.06.01-ЭЭС
28	HUV	ХӨВСГӨЛ ГЕОЛОГИ	324.7	21.6	6.7%	150.0	2020.04.03	2020.05.01-ЭЭС
29	SUU	СҮҮ	5,668.0	1,715.1	30.3%	5.0	2020.03.27	2020.05.01-ЭЭС
30	HZB	ГАН ХЭРЛЭН	31.9	15.0	46.9%	150	2020.04.06	2020.09.30-НЫ ДОТОР
31	BTG	БАЯНТЭЭГ	2,166.2	500.0	23.1%	1,979.3	2020.02.07	2020.12.01-НИЙ ДОТОР
32	TTL	ТАВАН ТОЛГОЙ	48,062.7	43,238.0	90.0%	821.0	2020.04.03	2020.05.31-НИЙ ДОТОР
33	ERS	МОНГОЛ АЛТ	71.3	39.9	55.9%	150.0	2020.04.29	2020.12.31-НИЙ ДОТОР
34	TEE	ТЭЭВЭР ДАРХАН	10.9	0.8	749.1%	500.0	2020.04.29	2020.12.31-НИЙ ДОТОР

ХӨРӨНГИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН МЭДЭЭ

ОНЦЛОХ МЭДЭЭ



Компанийн тухай хуулийн 46-р зүйлийн 46.5-д заасны дагуу 2020 онд нэр бүхий 31 ХК-аас 4.8 тэрбум ширхэг хувьцаанд ногдох нийт 94.2 тэрбум төгрөгийн ногдол ашиг тараахаар ТУЗ-ийн шийдвэрийг Хороонд ирүүлсэн. 2020 оны 05-р сарын 31-ний өдрийн байдлаар “Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв” ХХК-тай нэр бүхий 8 ХК гэрээ байгуулж, 16,507 хувьцаа эзэмшигчийн 315.0 сая ширхэг хувьцаанд ногдох нийт 4.3 тэрбум төгрөгийг байршуулж, хувьцаа эзэмшигчдэд ногдол ашиг тараасан байна.

Эх сурвалж: Санхүүгийн Зохицуулах Хороо

ХУВЬЦААТ КОМПАНИУДЫН МЭДЭЭЛЭЛ

“Эрдэнэ Ресурс Девелопмент Корпорэйшн” /MSE: ERDN, TSX: ERD/ ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал боллоо.

“Эрдэнэ Ресурс Девелопмент Корпораци” /MSE: ERDN, TSX: ERD) нь 2020 оны 06-р сарын 25-ны өдөр Нова Скошиа мужийн Халифакс хотод хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг зохион байгууллаа.

Хурлаар Төлөөлөн Удирдах Зөвлөлийн гишүүдийг болон аудитын компанийг сонгосон бөгөөд хувьцаа эзэмшигчдийн эрхийн төлөвлөгөөг үргэлжлүүлэх эсэхийг батлах, ирээдүйд олгогдох хувьцааны эрхийн хөтөлбөрт өөрчлөлт оруулах зэрэг асуудлыг хэлэлцэн баталлаа.

Компанийн дүрмийн дагуу ТУЗ-ийн гишүүдийн тоо 3-аас багагүй, 10-аас ихгүй байх бөгөөд жил тутам сонгогддог билээ. Энэ удаад 8 гишүүнийг сонгосон бөгөөд тэдэн дундаас компанийн гүйцэтгэх захирлаар Питер Акерли, ТУЗ-ын даргаар Т.Лэйтон Крофт, санхүү албаны даргаар Роберт Женкинс, ерөнхий нарийн бичгийн даргаар Сюзан Фрейзер нар тус тус ажиллахаар болсон байна.

Эх сурвалж: Монголын Хөрөнгийн Бирж

“Ард даатгал” /MSE: AIC/ ХК-ийн хувьцаа эзэмшилд томоохон өөрчлөлт гарав.

Ард даатгал /MSE: AIC/-ийн хөрөнгө оруулагчдын бүтцэд анхаарал татахуйц өөрчлөлт гарлаа.

Тус компанийн томоохон хөрөнгө оруулагчид нь “Ард санхүүгийн нэгдэл” /MSE: AARD/ ХК /66.78%/ болон “БиДиСек” /MSE: BDS/ ХК /5.77%/ байсан бөгөөд 3 дахь том хөрөнгө оруулагч нь тодорхой бус байсан юм. 2020 оны 06-р сарын 19-ний байдлаар нөлөө бүхий хувьцаа эзэмшигчид компанийн нийт хувьцааны 76.96%-ийг эзэмшиж байжээ.

Харин дээрх өөрчлөлтөөр “Ард даатгал” /MSE:AIC/ ХК-ийн нөлөө бүхий хувьцаа эзэмшигч 2 болж, тэдгээрийн хувь эзэмшил нь 71.25% болж буурсан байна. Ингэснээр компанийн 5%-аас бага хувьцаа эзэмшигчдийн хувь хэмжээ 28.75 болон өсөж, хөрөнгө оруулагчдын тоо 1,925 боллоо.

Эх сурвалж: Монголын Хөрөнгийн Бирж



“Улсын их дэлгүүр” /MSE:UID/ ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн анхааралд.

“Улсын их дэлгүүр” /MSE:UID/ ХК-ийн барилгад гал түймрийн аюул нүүрлэж, томоохон гарз хохирол тохиолдсонтой холбогдуулан “Монголын хөрөнгийн бирж” ТӨХК-ийн зүгээс хувьцаа эзэмшигчид болон олон нийтэд нөхцөл байдлын талаар үнэн бодит мэдээ, мэдээллийг түргэн шуурхай хүргэж ажиллах талаар 2020 оны 06-р сарын 08-ны өдөр явуулсан албан тоотын хариуг ирүүллээ. Үүнд:

- Учирсан хохирлын хэмжээг тогтоох, хор хохирлыг бууруулах, үүсээд буй асуудлыг шийдвэрлэх зорилгоор ОБЕГ, НМХГ, Шүүхийн шинжилгээний хүрээлэн, цагдаагийн албан хаагчид болон даатгалын байгууллагын шинжээчидтэй хамтран ажиллаж байгаа бөгөөд хохирлын хэмжээг бүрэн тодорхойлж дуусаагүй байна.
- “Улсын их дэлгүүр” /MSE:UID/ ХК нь “Номин даатгал” ХХК-тай Үл хөдлөх хөрөнгийн даатгал, Байгууллагын хариуцлагын даатгалын гэрээг тус тус байгуулсан байсан.
- Цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээг албаны ёсны дүгнэлт гарсны дараа тодорхойлохоор ажиллаж байгаа талаар хариу албан тоотой ирүүлсэн бөгөөд цаашид боломжит бүх мэдээллийг тухай бүрд олон нийтийн мэдээллийн хэрэгсэл ашиглан олон нийтэд хүргэн ажиллахаа мэдэгдсэн байна.

Эх сурвалж: Монголын Хөрөнгийн Бирж

ЗАХ ЗЭЭЛИЙН БУСАД МЭДЭЭ

ОНЦЛОХ МЭДЭЭ

Азийн хөгжлийн банк шинэ тайландаа Монгол Улсад тогтвортой шинэчлэл чухал байгааг онцоллоо.

Макро эдийн засгийн менежментээ сайжруулах, хүний хөгжлийг бэхжүүлэх, олон улсын худалдааг өргөтгөх, уул уурхайн салбар болон бусад салбарт олж авсан мэдлэг, туршлагадаа үндэслэн эдийн засгаа төрөлжүүлэх чиглэлүүдэд илүүтэй төвлөрснөөр тогтвортой бөгөөд хүртээмжтэй эдийн засгийг цогцлоож чадна гэжээ.

Эх сурвалж: BloombergTV.mn



МАКРО ЭДИЙН ЗАСАГ

Монголбанкны Мөнгөний бодлогын хорооны 2020 оны 06-р сарын 26-ны өдрийн ээлжит хурлаар:

1. Эдийн засаг, санхүүгийн зах зээлийн өнөөгийн байдал, ирээдүйн төлөв болон гадаад, дотоод орчны тодорхой бус байдлыг харгалзан үзээд бодлогын хүүг хэвээр хадгалах.
2. Банкны системийн тогтвортой байдлыг хангах үүднээс банкны эх үүсвэрийн долларжилтыг бууруулах, төгрөгийн харьцангуй өгөөжийг хадгалах зорилгоор өндөр хүүтэй гадаад валютын хадгаламж болон хүү төлж буй гадаад валютын харилцахын эзлэх хувиар банканд олгох төгрөгийн заавал байлгах нөөцийн урамшууллыг бууруулан тооцох шийдвэрийг тус тус гаргалаа.

Эх сурвалж: Монголбанк

ТҮҮХИЙ ЭДИЙН ЗАХ ЗЭЭЛ

Оны эхнээс 06-р сарын 18-ны өдөр хүртэлх хугацаанд 7.7 сая тонн чулуун нүүрсийг 623.2 сая ам.доллаароор экспортолсон байна.

Өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад биет хэмжээ нь 2.1 дахин бага, мөнгөн дүн нь 2.3 дахин бага байгааг Гаалийн ерөнхий газрын урьдчилсан гүйцэтгэлээс харж болохоор байна. Сүүлийн сар орчмын хугацаанд Гашуунсухайт боомтоор өдөрт 400-700 автомашинаар нүүрс экспортолж байгаа юм. Түүнчлэн Шивээ хүрэн боомтоор өдөрт 450-500 орчим автомашин нүүрс гаргаж байгаа талаар боомтууд мэдээлж байна.

Эх сурвалж: BloombergTV.mn



МЭДЭГДЭЛ

Энэхүү хэвлэл /мэдээлэл, судалгаа/ нь "Ти Ди Би Капитал ҮЦК" ХХК-ийн нэрийн өмнөөс зөвхөн өөрийн үйлчлүүлэгчид /харилцагчид/-д мэдээлэл хүргэх зорилгоор бэлтгэгдсэн ба энэ нь аливаа нэг хөрөнгө оруулалтын зөвлөгөө болон аливаа санхүүгийн хэрэгслийг худалдах, худалдан авах санал биш болно. Судалгаа /хэвлэл/-г бэлтгэх үеийн байдлаар түүнд агуулагдаж буй мэдээллийн үнэн бодит байдлыг хангах талаар шаардлагатай ажиллагааг хийсэн бөгөөд "Ти Ди Би Капитал ҮЦК" ХХК нь мэдээллийн үнэн бодит байдалд баталгаа гаргахгүй. Энэхүү мэдэгдэлд агуулагдаж буй мэдээллийг үйл ажиллагаандаа шууд болон шууд бус байдлаар ашигласнаас үүдэн аливаа хувь хүн, хуулийн этгээдийн үйл ажиллагаанд учирсан хохиролд "Ти Ди Би Капитал ҮЦК" ХХК хариуцлага хүлээхгүй болно.